



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/87

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 5/10 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.4.1, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/853 тоот захирамж, Газрын дүрмийн 2.5.3, 3.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аялал жуулчлалын салбарын мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор “Аялал жуулчлалын тогтвортой хөгжил” сэдэвт сургалтыг 2017 оны 12 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд Дэлхийн Аялал жуулчлалын байгууллагын зөвлөх, зочлох үйлчилгээний олон улсын эксперт, сургагч багш, судлаач Стив Нөүксийн удирдлага дор зохион байгуулахыг Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Тулгаа/-д үүрэг болгосугай.

2. “Аялал жуулчлалын тогтвортой хөгжил” сэдэвт сургалтыг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Сургалтыг зохион байгуулахад шаардагдах төсөв болох 9.640.000 / есөн сая зургаан зуун дөчин мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА *D. Balsm* Д. БАТСҮХ



1150500322

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 11 сарын 16
өдрийн 117 дугаар тушаалын хавсралт



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ”
СЭДЭВТ СУРГАЛТЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА


2017 оны 11 сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Сургалт зохион байгуулах заалны түрээс /2 удаагийн цайны завсарлагааны үнэ багтсан/	өдөр	2	1 650 000	3 300 000
2	Тэрэлжид явуулах сургалтын заалны түрээс /2 удаагийн цайны завсарлагааны үнэ багтсан/	өдөр	1	1 500 000	1 500 000
3	Синхрон орчуулгын төхөөрөмж, чихэвчийн түрээс	ш	150	6 870	3 090 000
4	Орчуулагчийн ажлын хөлс	өдөр	3	400 000	1 200 000
5	Сургалтын тараах материал хэвлэх /бичгийн цаас/	ш	20	-	-
6	Сургалтын тараах материал хэвлэх /хор/	ш	2	-	-
7	Сертификат хэвлүүлэх	ш	150	1 670	250 000
8	Цэвэр ус	ш	600	500	300 000
Нийт дүн					9 640 000

--oo0oo--

ХЯНАСАН:
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

 Б.БАТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:
СТАТИСТИК, СУРГАЛТ,
СУДАЛГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

 Б.ЕРБАХЫТ